

Монгол улсад гэр оронгүйдлийн асуудлыг бууруулах, үгүй болгоход тулгарч буй сорилт бэрхшээл, боломжууд



Монгол улсын Гэр бүл,
хөдөлмөр, нийгмийн
хамгааллын яаманд зориулж
Дэлхийн гэр оронгүйдлийн
асуудлаарх хүрээлэнгээс
боловсруулан хүргэв



Нэршил, нэр томъёоны орчуулга:

1. Institute of Global Homelessness IGH- Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн-ДГОАХ
2. Vanguard Country Partnership- Улс орнуудтай хийсэн Вангаардын Хамтын Ажиллагаа
3. Shelter- Түр хоноглох байр
4. Point-In-Time method- “Тухайн цаг мөч”-ид буюу нэг шөнийн дотор тоолох судалгааны арга
5. UN Habitat- НҮБ-ын хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр

Товчилсон нэрс:

1. ДГОАХ- Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн
2. ХНХЯ- Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
3. БХБЯ- Барилга, Хот Байгуулалтын Яам
4. НҮБ- Нэгдсэн Үндэсний Байгууллага
5. ҮСХ- Үндэсний Статистикийн Хороо
6. ҮСИ- Үндэсний Сайн дурын Илтгэл
7. НХТТ- Нийгмийн Хамгааллын Тусгай Төв
8. АГОХЗ- АНУ-ын Гэр Оронгүйдлийн Хамтарсан Зөвлөл

Танилцуулга

Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн (ДГОХ) -гийн төлөөлөгчид Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамтай байгуулсан “Вангаард Хөтөлбөрийн Улс орнуудтай хийх Хамтын Ажиллагаа”(цаашид Вангаардын хөтөлбөр гэх)-ны хүрээнд 2024 оны 3-р сарын 4-нөөс 12-ны хооронд Монгол Улсад айлчлав. Улаанбаатар хотод байх үеэр бид хатагтай Б.Ундралаар ахлуулсан Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны ажилтнууд, Нийслэлийн засаг даргын орлогч Одсүрэнгийн Номинчимэг, Үндэсний Статистикийн Хорооны дарга Батмөнхийн Батдаваа, Барилга, Хот Байгуулалтын Яам зэрэг төр засгийн төлөөлөл, Нэгдсэн Үндэсний Байгууллагын агентлагуудын төлөөлөгчидтэй уулзаж, түр хоноглох байруудтай танилцав. Дархан-Уул аймагт бид С.Энхболд даргатай Аймгийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газрын хамтран ажилладаг байгууллагууд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалтай уулзаж, түр хоноглох байрууд, шинээр байгуулагдсан архины зүй бус хэрэглээний эмчилгээний төвд зочлов. Мөн тус аймагт бид хөдөө орон нутгийн уламжлалт малчин гэр бүлд зочилж ажил амьдралтай нь танилцсан. Бидний айлчлалд Когнос Интернэйшнл судалгааны компанийн захирал Ө.Эрдэнэчимэг ихээхэн дэмжлэг үзүүлсэн юм.

Энэхүү айлчлал нь Монгол Улсыг гэр оронгүйдлийн судалгаа, тооцоолол хийх, энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2023 оны 3-р сард гарын үсэг зурсан “Вангаард Хөтөлбөрийн Улс орнуудтай хийх Хамтын Ажиллагаа”-ны гэрээний хүрээнд хийгдсэн юм. Айлчлалын үеэр Монгол улсад гэр оронгүйдлийг арилгахын төлөө тэргүүн шугамд ажиллаж буй хүмүүс, төр засгийн ажилтнууд болон бусад оролцогч талуудын хүчин чармайлт гаргаж буйд маш их сэтгэл ханамжтай байна. Мөн бид олон улсын судалгаан дээр үндэслэн гэр оронгүйдлийг бүрэн дүүрэн урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх системийг бий болгох хэрэгцээ шаардлагын талаар ярилцсан. Энэхүү тайлангаар Монгол улсад гэр оронгүйдлийг таслан зогсоох ажлыг хурдасгах олон улсын

шилдэг туршлага, ололт, мэдээллийг танилцуулж байна. Бидний зочилсон түр хоноглох газрууд цэвэр нямбай, үйлчлүүлэгчиддээ өндөр түвшний анхаарал халамж тавьж байсан ба үйлчилгээгээ улам илүү олон төрөл болгож, ажилтнууд нь хандлага, арга барилаа улам сайжруулахыг эрмэлзэж байгаа нь харагдсан. Дархан-Уул аймгийн удирдлага хөдөлмөр эрхлэлт, бичиг баримт, халамж үйлчилгээ зэргийг иргэдэд нэг дороос үзүүлэхээр төвлөрүүлсэн бөгөөд, сэргээн засах төв, орон сууцжуулах зэрэг шинэ хөтөлбөрүүдийг туршихаар ажиллаж эхлээд байна. Цагдаа, боловсрол, эрүүл мэнд, хотжилт зэрэг олон салбарт гэр оронгүйдлийн асуудал улам ихээр хөндөгдсөөр байна. Энэ талын мэдээллийн эх үүсвэрүүд хангалттай байгаа ба Азийн Хөгжлийн Банкны захиалгаар хийгдсэн судалгаанд хэрэгтэй чухал мэдээллүүд байна. Харин энэхүү асуудлыг шийдвэрлэх, одоогийн нөхцөл байдлыг сайжруулахуйц бодлогын шийдвэр гаргах, шинэ хөтөлбөрүүд хэрэгжүүлэхдээ эдгээр судалгааны мэдээллүүдийг ашиглах л хэрэгтэй байна.

Одоо байгаа давуу талууд дээрээ үндэслэн тогтолцоог зөв тал руу нь өөрчлөх, гэр оронгүй иргэдийн нөхцөлийг сайжруулах дараах боломжууд байна:

- Гэр оронгүй хүмүүсийг түр хоноглох байрнаас тогтвортой, байнгын гэр оронд шилжүүлэхийн тулд орон сууц, байрны сонголтыг өргөжүүлэх;
- Тусламж үйлчилгээг улам илүү сайжруулах, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдтэй уялдаа холбоог бэхжүүлэх;
- Эмэгтэйчүүд, хүүхэдтэй ээжүүд гэх зэрэг харилцан адилгүй хэмжээний орлоготой хүмүүст дэмжлэг үзүүлэх зорилгоор хямд үнэтэй орон сууцны хувилбарыг олшруулах;
- Цаг уурын өөрчлөлт болон ажил хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагын үүднээс хөдөө орон нутгаас хот руу шилжин суурьшиж буй хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар гэр оронгүйдлээс урьдчилан сэргийлэх.

Монгол улс гэр оронгүйдлийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Монголд байгаа гэр оронгүй иргэд амь насаа алдах өндөр эрсдэлтэй, онцгой эмзэг нөхцөлд байна. Урьд урьдаас илүү олон хүн баталгаат бус байранд амьдарч байгаа ба үүний зэрэгцээ амьдрах зардал улам ихэсч байгаа энэ үед улам олон хүмүүс гэр оронгүй болох эрсдэл дунд байна. Одоогоор үндэсний хэмжээнд гэр оронгүй хүмүүсийн тоог гаргах, түүнчлэн гэр оронгүйдлийн талаар иж бүрэн цогц бодлого байхгүй байна. Гэр оронгүйдэл нь Монгол улсын хувьд үхэл амьдралын асуудал болсон байгаа ч зөв зохицуулалт, төр засгийн хүчтэй удирдлагатайгаар гэр оронгүйдлийн асуудлыг шийдвэрлэж болдгийг та бид мэднэ. Гэр оронгүйдлийн асуудлыг цогцоор нь шийдсэнээр Хөгжлөөс хэн ч үлдэж, орхигдох ёсгүй гэсэн НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгод хүрэхээр урагшилж байгаа Монгол улсад түлхэц болж өгөх юм.

Дэлхийн гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн Монгол улсын ХНХЯ-тай 2023 оны 3-р сард гарын үсэг зурсан “Вангард Хөтөлбөрийн Улс орнуудтай хийх Хамтын Ажиллагаа”-ны гэрээний дагуу Монгол улсыг дараах зорилгын хүрээнд дэмжин ажиллах болно:

- Монгол улсад Гэр оронгүйдлийг бууруулах, таслан зогсоох үндэсний бодлого боловсруулах;

- Үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд гэр оронгүй байсан ба одоо гэр оронгүй амьдарч байгаа иргэд, ТББ-уудтай зөвлөлдөх;
- Улаанбаатар, Дархан болон хөдөө орон нутагт гэр оронгүйдлийн тархсан байдлыг газарзүйн хувьд тогтоох, суурь судалгааны эхлэл бий болгох зорилгоор 2024 онд анх удаа “Тухайн цаг мөч”-ид буюу нэг шөнийн дотор тоолох судалгааны аргаар тооллого явуулах;
- 2024 онд гэр оронгүйдлийг бууруулах зорилтуудыг тогтоох.

Вангаард хөтөлбөрийн дараагийн алхмууд:

- Иргэний нийгэм, цагдаа, төрийн байгууллагууд (эрүүл мэнд, боловсрол, барилга, хот төлөвлөлт)-ын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан 2024 оны “Тухайн цаг мөч” тооллогыг төлөвлөх ажлыг эхлүүлэх;
- Иргэний нийгмийг хамруулсан оролцогч талуудын судалгааг жилд нэг удаа хийх;
- НҮБ-ын Гэр оронгүйдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах иж бүрэн цогц бодлогууд, холбогдох нэршил, хэмжих нэгжийн талаарх шийдвэр, зөвлөмжүүдтэй нийцсэн бодлогын баримт бичгийг боловсруулах.

I. ДГОХ-ийн товч танилцуулга

Дэлхийн Гэр оронгүйдлийн асуудлаарх хүрээлэн (ДГОХ) гэр оронгүйдлийг арилгахад дэлхий нийтээр тэмцэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Хүн бүр баталгаатай, аюулгүй, хэнээс ч үл хамаарсан, аливаа боломжийг олгосон гэр оронтой байх явдал бол бидний алсын хараа, туйлын зорилго юм. АНУ-ын Чикаго хот дахь ДеПол Их сургууль, Их Британийн Лондонд байрлах ДеПол Интернэйшнл байгууллагуудын хамтын ажиллагаанаас 2014 онд ДГОХ үүсэн байгуулагдсан бөгөөд гудамжинд болон тусгай хоноглох газруудад амьдарч байгаа иргэдэд онцгойлон анхаарч гэр оронгүйдлийг дэлхийн хэмжээний асуудал болгон анхаарсан анхны байгууллага юм.


ДГОХ нь НҮБ болон дэлхийн олон орны үндэсний, орон нутгийн болон бүс нутгийн түвшний төр засгийн байгууллагууд, иргэний нийгэм, сургалт, судалгааны байгууллагууд болон гэр оронгүй амьдралд орж байсан иргэдтэй хамтран ажиллаж, гэр оронгүйдлийг үндэсний болон олон улсын хэмжээнд таслан зогсоох боломжийн тухай дуу хоолойгоо хүчтэй хүргэсээр байгаа билээ. Бид дэлхийн улс орнуудад гэр оронгүйдлийг хэмжих тодорхой хэмжүүртэй байх, гэр оронгүйдлийг бууруулж, улмаар устган арилгах туйлын зорилгод нэгдэх, түүнд хүрэх үр дүнтэй арга замуудыг гишүүн орнуудад түгээх дэлхий нийтийн хөдөлгөөнийг дэмжихийг уриалан ажилладаг. НҮБ-ын ТББ-ын Ажлын хэсэг болон бусад олон орны байгууллагуудтай бидний хамтарсан гэр оронгүйдлийг арилгах нөлөөллийн ажлуудын үр дүнд энэхүү асуудалд дэлхий нийтийн анхаарал илүү нэмэгдсэн. Түүнчлэн, НҮБ-ын тогтолцоонд гэр оронгүйдлийн асуудлыг улам илүү таниулах, гишүүн орнуудад гэр оронгүйдэлд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад техникийн болон чадавхи бэхжүүлэх туслалцаа дэмжлэг үзүүлэх, дэлхийн гэр оронгүйдлийн талаарх мэдээлэл цуглуулах ажлыг илүү сайн төлөвлөх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор НҮБ-ын Хүн амын Нутагшил, Суурьшлын Хөтөлбөр байгууллагатай албан ёсны харилцаа тогтоосон.

ДГОХ нь нотолгоонд суурилсан сайн туршлагууд болон шинээр гарч байгаа санаачлагуудыг хамтран ажиллагч байгууллагууддаа дараах хэд хэдэн замаар хуваалцдаг.

ДГОХ -ийн HUB төв нь гэр оронгүйдлийн асуудлаар ажиллаж байгаа хүмүүст ажлын хэрэгцээндээ судалгааны болон баримт мэдээлэл авахад нь туслах зорилготой дэлхийн мэдээлэл, мэдлэгийн төвийн үүргийг Community of Impact Сүлжээгээрээ дамжуулан гүйцэтгэдэг. Тус Сүлжээ нь гэр оронгүйдлийн асуудалд үр дүнтэй шийдлүүдийг санал болгох, мэргэжилтэн, шинжээчдийг оролцуулсан вэбинар, гэр оронгүйдлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн шийдлүүдэд оруулах хувь нэмрийг дэмжих зорилготой эрдэм шинжилгээний Олон Улсын Гэр Оронгүйдлийн Сэтгүүл (ОУГОС)-ийг эрхлэн гаргах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. ДГОХ нь ОУГОС-ийн бага хурлын хамтран зохион байгуулагчаар ажилладаг бөгөөд тус хурал 2023 онд Чикагод болсон, мөн 2025 онд Чили улсад болох юм.

А. Вангаард хөтөлбөр

Вангард хөтөлбөрт хамтран ажиллаж буй дэлхийн олон орны хот, бүс нутаг, улс орнууд өөр өөрийн орон нутгийн онцлог, нөхцөл байдалдаа тохируулан гэр оронгүйдлийг дорвитой бууруулах буюу тэглэх зорилго тавин ажилладаг. Энэхүү санаачилга нь орон нутгийнхны мэргэжлийн ур чадвар, шинэ санаа, санаачлагыг дэмжин хөгжүүлэх зорилготой бөгөөд нутгийн болон дэлхийн түвшинд мэдлэг, мэдээллээ харилцан солилцох боломж олгодог. ДГОХ нь гэр оронгүйдлийг тэглэхэд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, удирдагчдыг дэмжих зорилгоор гэр оронгүйдлийн мэргэжилтнүүдийн дэлхийн сүлжээг ашиглан тодорхой техникийн тусламж үзүүлдэг. Цаашилбал, энэхүү хамтын ажиллагааны хүрээнд гэр оронгүйдлийг тэглэх төлөвлөгөөг дэмжих, оролцогч талуудыг хамтран ажиллахыг уриалах, Вангард сүлжээгээр дамжуулан сайн туршлагаа олон улсын түвшинд хуваалцах боломжоор хангах замаар хотуудын үйл ажиллагааг дэмждэг.



В. Вангард хөтөлбөрийн олон улсын үнэлгээний зөвлөмжүүд

Вангард хөтөлбөрт хамрагдаж буй хотуудын гудамжны гэр оронгүйдлийг тэглэх: Херриот-Уатт их сургуулийн I-SPHERE (Их Британий улсын Херриот-Уатт их сургуулийн

дэргэдэх судалгааны төв) болон GISS Bremen (Герман улсын судалгааны байгууллага)-ийн хамтран хийсэн олон улсын харьцуулсан судалгаагаар ДГОХ-ийн Вангардын эхний жилийн 13 хотын гудамжны гэр оронгүйдлийг шийдвэрлэхэд үр дүнтэй, болон үр дүнгүй арга хэмжээнүүдийг судлаад дараах зөвлөмжийг өгсөн:

Үр дүнтэй арга хэмжээнүүд	Үр дүнгүй арга хэмжээнүүд
• Гэр оронгүйдлийг удирдан зохион байгуулахаас илүүтэйгээр түүнийг бууруулах бодит ажил хэрэг рүү анхаарлыг шилжүүлэх; • Төрийн болон төрийн бус аль нэгэн салбараас гэр оронгүйдлийн асуудалд чиглэсэн тодорхой зорилго, хүчин чармайлттай үйл ажиллагааг тэргүүлэн удирдах удирдагчтай байх; • Гэр оронгүй хүмүүсийг тодорхойлж, бүртгэн хянадаг орон гэргүйчүүдийн үйлчилгээний зохицуулалттай нэвтрэх систем бий болгох; • Илүү онцгой тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүсийн ганцаарчилсан хувийн бүртгэл хөтлөх; • Нийгэд нь нэг аргыг хэрэглэхгүйгээр бүлэг тус бүрийн онцгой хэрэгцээнд тохируулан арга замаа сонгох; • Гудамжинд хүрч үйлчлэх үйлчилгээ- тэнэмэл амьдралаас гарах, шөнөдөө хоноглуулдаг төвийн амьдралаас татан гаргахад туслах үйлчилгээ; • Яаралтай үед түр байрлуулах, тодорхой шаардлагыг хангасан зохистой байраар хангах (шууд байрлуулах байр байхгүй тохиолдолд) – аюулгүй, сайн зохион байгуулалттай, нэр төртэй, аль болох цөөн тооны хүмүүс нэг өрөөнд орох эсвэл ганцаарчлан орох боломжоор хангах; • Тогтвортой байранд нэн даруй оруулах;	• Дэлхийн хөгжингүй болон хөгжиж буй орнуудад аль алинд нь түгээмэл хэрэглэсээр ирсэн том хэмжээний, нийтийн түр хоноглох байр ашиглах; • Гэр оронгүй хүмүүст үзүүлэх үйлчилгээг шашны байгууллагуудад хэт ихээр найдан хийлгэх нь бие физиологи, шүтэн бишрэх хэрэгцээ рүү анхаарлыг шилжүүлж, тогтолцооны дутмаг хангалтгүй байгаа асуудал анхаарлын гадуур үлдэх сул талтай; • Тусламж дэмжлэг (орон байр, түр хоноглох байр г.м) үзүүлэх зорилгогүйгээр цагдаа, хотын удирдлагаас түрэмгийлэн хүч хэрэглэн оролцох нь гэр оронгүй хүмүүсийн хувьд “хаалга хаагдах”-ад хүргэдэг; • Тусламж дэмжлэг авах боломжийг зөвхөн иргэний үнэмлэх, иргэншлийн статус болон “танил, холбоо”-гоор олгохоор хязгаарлах; • Урьдчилан сэргийлэх арга хэмжээ байхгүй- ихэнх хотууд шорон, эмнэлэг, асрамжийн газар зэрэг гэр оронгүйдэлд шууд шилжих магадлал өндөртэй газруудаас гудамжинд гарах эрсдэлийг урьдчилан сэргийлсэн арга хэмжээнд маш бага анхаарал хандуулдаг

• Орон гэртэй болох, түүндээ тогтмол суурьшихад нь санхүүгийн, сэтгэлзүйн болон практик тусламж үзүүлэх (Эрчимтэй тусламж дэмжлэг хэрэгцээтэй хүмүүст зориулсан Нэн тэргүүнд гэр орноор хангах буюу Housing First хөтөлбөрийн туслалцаа г.м); • Сэтгэлзүйн эрүүл мэнд, архи тамхи, мансууруулах бодисны зүй бус хэрэглээ болон бусад мэргэжлийн туслалцааг хэрэгцээтэй хүмүүст нь нөхцөл шаардлага тавилгүйгээр үзүүлэх; • Гэр бүлийнхэнтэйгээ эвлэрэх	
--	--

II. НҮБ -ээс гэр оронгүйдлийн асуудалд анхаарсан байдал

Сүүлийн 5 жилд, гэр оронгүйдлийн асуудал НҮБ-ын хувьд улам их анхаарал татсан асуудал болсоор байна. 2020 оны 6-р сард НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл Гэр Оронгүйдлийн тогтоол (E/RES/2020/7), 2021 оны 12-р сард Ерөнхий Ассамблей мөн Гэр оронгүйдлийн тогтоолыг (A/RES/76/133) баталж, хамгийн сүүлд 2023 оны 7-р сард НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын гэр оронгүйдлийн тайлан (A/78/236) гаргасан байна. Эдгээрийг оролцуулан олон тооны бусад тогтоол шийдвэр, тайлангууд гэр оронгүйдлийг дэлхийн хэмжээний асуудал гэж үзсэн бөгөөд дэлхий нийтээрээ энэхүү асуудалд шийдэл гаргах, гэр оронгүйдлийн асуудлыг Тогтвортой Хөгжлийн Зорилго #1 “Ядуурлыг арилгах”, Зорилго #11 “Тогтвортой хот, орчныг бий болгох” -той холбох шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Эдгээр тогтоол, тайлангууд гэр оронгүйдлийг гурван үндсэн ангилалд хуваасан: 1) гудамж, задгай орчин, хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч буй хүмүүс; 2) гэр оронгүй иргэдэд зориулсан түр хоноглох байранд амьдарч буй иргэд; 3) тухайн улсын хууль эрхзүйд заасан бол, амьдарч буй сууцных нь эзэмших эрх нь баталгаажаагүй, суурь үйлчилгээнд хамрагдаагүй, амьдран суух нөхцөл нь ноцтой зөрчигдсөн иргэдийг хамааруулсан байна. Дээрх тогтоол, тайлангууд гэр оронгүйдлийн бүх хэлбэрийг НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд заасан зохистой сууцанд амьдрах хүний эрхийн зөрчил гэж хүлээн зөвшөөрсөн байна.

Цаашилбал, эдгээр тогтоол, тайлангууд НҮБ-ын гишүүн орнуудад хандан гэр оронгүйдлийн талаархи хүн амзүйн мэдээллийг нарийвчлан цуглуулж, гэр оронгүйдлийн ангиллуудыг тогтоон, одоогийн хэмжих аргачлалуудыг хамтран хэрэглэхийг уриалж, үндэсний болон дэлхийн түвшинд бодлого боловсруулахад гэр оронгүйдлийн мэдээллийг хэмжих, цуглуулах үйл явцыг нэгтгэн, гэр оронгүй иргэдэд нөлөөлөх нэгдсэн, бүх талын оролцоог хангасан, үр дүнтэй бодлого, хөтөлбөрүүд боловсруулахыг уриалсан.

ДГОХ тус тогтоолуудын зүгээс гэр оронгүйдлийн асуудалд хандсан уриалгуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, тайлангуудын талаар чиглэл, зөвлөмж өгөх зорилгоор орон нутгийн болон үндэсний түвшний засгийн газрын байгууллагуудад

техникийн туслалцаа үзүүлэхээр НҮБ-ын Хүн амын Нутагшил, Суурьшлын Хөтөлбөр (НҮБ-Хабитат)- тэй албан ёсоор хамтран ажиллаж байна.

Гэр оронгүйдлийн асуудалд дэлхийн, үндэсний болон орон нутгийн хүчин чармайлтыг хамтруулан нэгтгэх зорилгоор НҮБ-ын байранд олон тооны оролцогч талуудтай уулзах боломж гарсанд талархаж байна. НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэх, орон нутгийн болон үндэсний зорилтуудыг дэлхий нийтийн зорилгод нийцүүлэхэд гаргаж буй хичээл зүтгэлийг үнэлж байна.

Дэлхийн олон орнууд гэр оронгүйдлийн асуудлыг НҮБ-ын Үндэсний Сайн дурын Илтгэл (ҮСИ)- дээ оруулсан байдаг. Тэдгээр орнууд гэр оронгүйдлийн асуудлыг Тогтвортой Хөгжлийн зорилт #1-ийн дор Ядуурлыг устгах, мөн Тогтвортой Хөгжлийн зорилт #11-ийн дор Тогтвортой Хот, орон нутаг гэсэн хэсгийн дор оруулсан байдаг. Монгол улс 2023 оны ҮСИ-дээ гэр оронгүйдлийн асуудлыг Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын “хөгжлөөс хэн ч үлдэх, хоцрох ёсгүй” гэсэн зарчмын дор 2018 оны нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа, 2021 оны өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд хийсэн дүн шинжилгээгээр “гэр оронгүй тэнэмэл иргэд” бол боломж нь хязгаарлагдсан, тэгш бус байдалд өртсөн хүн ам юм хэмээн тодорхойлсон байна. НҮБ-ын зааварчилгааны дагуу гэр оронгүйдлийн асуудалд хандсан цогц бодлого боловсруулахад бид Монгол улсад туслахад бэлэн байна.

ДГОХ-ээс гаргасан гэр оронгүйдлийг тодорхойлох дэлхийн томьёолол

Энэхүү томьёолол нь дэлхийн зургаан тивийн судлаачид, бодлогын шинжээчид, энэ чиглэлийн ажлыг удирдан ажиллаж буй удирдах түвшний ажилтнуудтай хамтран ажилласны үр дүнд гарсан бүтээгдэхүүн юм.

Тус томьёололд гэр оронгүйдлийг нэгдсэн байдлаар “амьдрах зориулалтын наад захын шаардлага хангасан сууцны хүртээмжгүй байдал” гэж тодорхойлсон бөгөөд энэ ангилалд хамаарах орон сууцны төрлүүдийг нэрлэсэн байна.

Гэр оронгүй иргэн	Түр хоноглох төв болон эрсдэлт үед орогнох байранд амьдарч буй иргэн	Зохисгүй, аюулгүй бус орон сууцанд амьдарч буй иргэн
1А Гудамжинд эсхүл задгай газарт (цэцэрлэгт хүрээлэн, төмөр замын далан, гүүрний доор, замын хажуу, голын эрэг, ой мод гэх мэт) хонож буй иргэн 1В Хүн амьдрах зориулалтын бус сууцанд (автобус болон вагоны буудал, таксины зогсоол, эзэнгүй барилга, нийтийн барилга, байгууламж гэх мэт) хонож буй иргэн 1С Автомашин, хүн тэрэг, завь, бусад тээврийн хэрэгсэлд хонож буй иргэн 1D “Гудамж цэвэрлэгч” буюу оромж барьж, нэг цэгт тогтмол амьдардаг иргэн, өрх айл	2А Түр хоноглох байранд хонож буй иргэн (орой бүр унтах газраа хайж олно) 2В Гэр оронгүй иргэдэд зориулсан төв болон бусад түр хоноглох төвд амьдарч буй иргэн (өрөө, ор хуваарилж өгдөг) 2С Гэр бүлийн хүчирхийллээс зугтан түр хамгаалах байранд буй хүүхэд, эмэгтэйчүүд 2D Дотооддоо шилжин суурьшсан иргэдэд зориулсан хуаранд байрлаж буй зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг, хүнээс үүдэлтэй гамшиг, хүний эрхийн зөрчил, хөгжлийн гэх мэт шалтгааны улмаас орон гэрээсээ дайжсан, ингэхдээ хил даваагүй дотооддоо оршин сууж буй иргэн 2Е Орогнол хүсэгчид, дүрвэгсэд болон цагаач иргэдийг хүлээн	3 А. Түр хугацаанд найз нөхөд, ах дүү, хамаатан садангийнхаа гэрт амьдарч буй иргэн 3В. Хүчирхийлэлд өртөх эрсэлд амьдарч буй иргэн 3С. Хямд зочид буудал, дэн буудалд амьдарч буй иргэн 3D. Хүн амьдрах зориулалтын бус сууцанд шахцалдан амьдарч буй иргэн 3Е. Хүн амьдрах зориулалтын бус сууцанд амьдарч буй иргэн 3F. Чиргүүл, майханд амьдарч буй иргэн 3G. Хэт олуулаа амьдарч буй иргэн 3Н. Хүн амьдрах зориулалтын бус сууц, түр зуурын зориулалттай барилга байгууламж, ядуусын хороолол
	авах хуаран болон хүлээн авах/түр байрлуулах төвд байгаа иргэн	болон албан бус сууцанд амьдарч буй иргэн

III. Монгол улсаас Гэр оронгүйдлийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

А. Түр хоноглох байр, нийтийн байр

ДГОХ-ын ажилтнууд Улаанбаатар, Дархан хотуудад “Өлзийт-Асар” ТББ, Нийгмийн Хамгааллын Тусгай Төв (НХТТ), “Missionaries of Charity” түр хоноглох байр зэрэг хэд хэдэн түр хоноглох байр, нийтийн байруудаар очиж үзсэн.

Бидний очсон бүх түр хоноглох байр, төвүүдэд хоол хүнс, нийтийн унтлагын өрөө, гэр зэрэг үндсэн үйлчилгээ, эрүүл ахуй, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгааг ажигласан. Мөн ажил, бизнес эрхлэх, орлого олох үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэх сургалт эсвэл гэрчилгээ олгох боломжоор хангагдсан байсан. Ажилчид нь тулгарч байсан бэрхшээл, сорилтыг ойлгож, орон гэргүй болсон хүмүүст чин сэтгэлээсээ анхаарал халамж тавьж байгаа нь бидэнд мэдэгдэж байсан. Бидний зочилсон түр хоноглох байр, төвүүд бүгд цэвэрхэн, тохь тухтай, сонирхолтой чимэглэл, цэцэг ургамлаар чимэглэгдсэн, өнгөлөг байв. Уламжлалт, бие даасан амьдрах хэв маягийг эрхэмлэдэг иргэдэд зориулан нийтийн унтлагын өрөөнөөс гадна гэр барьж өгсөн байсанд бид гүнээ талархаж байлаа. Хэдийгээр зарим хоргодох байр, төвүүд өвлийн улиралд илүү их ачаалалтай ажилладаг ч бидний зочилсон түр хоноглох байрны хувьд иргэд шаардлагатай бол зуны саруудад байрлаж, зарим тохиолдолд хэдэн өвөл дараалан амьдрах боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, тэдний

оршин суух хугацаанд хязгаарлалт байхгүй байгаа нь маш эерэг, олон улсын шилдэг туршлагад нийцэж байгаа юм. Жилийн турш үйлчлэх ийм үйлчилгээг Монгол дахь бусад түр хоноглох байранд нэвтрүүлэхийг зөвлөж байна.

“Өлзийт Асралт” ТББ-ын түр хоноглох байр нь гэр оронгүй амьдарч байсан хүмүүс өөрсдийн санаачлагаар үүсгэн байгуулж ажиллуулдаг түр хоноглох байр гэдгээрээ онцлог юм. Эрдмийн зэрэг, гэрчилгээнээс хавьгүй илүү тэдний туулсан амьдралын туршлага нь түр хоноглох байр, түүний үйлчилгээг гэр оронгүй хүмүүсийг эдгээж, гэр оронгүйдлээс ангижруулах зорилготой яг нийцэж байгаа юм. Түр хоноглох байрны захирал болон оршин суугчид бие биедээ дэмжлэг үзүүлсэн сайн орчин бүрдүүлэхийг анхаарч ажилладаг. “Өлзийт Асралт” ТББ -д хэсэг хугацаанд амьдарч байсан оршин суугчдын ихэнх нь өвлийн улиралд голчлон хоол унд, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээгээр гудамжинд байгаа хүмүүст тусалцаа үзүүлэх ажилд идэвхтэй оролцож байна. “Өлзийт Асралт” ТББ болон Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ)-ны хооронд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа үүсэн хөгжиж, өвлийн улиралд ХНХЯ-аас “Өлзийт Асралт” ТББ-ын чадавхийг нэмэгдүүлэх санхүүжилтийг олгодог.

Улсын түр хоноглох байрны онцлог давуу тал бол оршин суугчдад үзүүлэх сэтгэлзүйн эмчилгээ, ажилд сургах, ажлын байраар хангах зэрэг цогц үйлчилгээ юм. Одоогийн захирал нь олон улсын томоохон ТББ-д ажиллаж байсан туршлагатай байгаа нь хүн төвтэй философийг хэрэгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой юм. Дархан-Уул аймаг дахь “Missionaries of Charity” түр хоноглох байрны онцлог давуу тал бол Дархан-Уул аймгийн ХНХЯ-ны хооронд үүсгэсэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бөгөөд ХНХЯ нь “Missionaries of Charity” түр хоноглох байранд үйл ажиллагаа явуулах санхүүжилтийг олгодог.

ХНХЯ өөр 6 түр хоноглох байранд санхүүжилт олгодог бөгөөд бид цаашид тэдгээр байруудаар зочилж, удирдах ажилтнуудыг оролцуулан техникийн тусалцаа үзүүлэх сонирхолтой байгаа.

В. Үйлчилгээг төрөлжүүлж, чанарыг сайжруулах талаар

Бид Улаанбаатар, Дархан дахь түр хоноглох байранд зочлохдоо үндсэн хэрэгцээг хангахаас гадна хөтөлбөр, дэмжлэгийг өргөжүүлэх боломжтой байгаа хандлагыг олж харсан. Хөтөлбөрүүдийг тодорхой дэд бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн чиглүүлж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг гэдгийг олон улсын туршлага нотлон харуулдаг. Дарханд гэр оронгүй хүмүүсийн цогц хэрэгцээг хангах хариу арга хэмжээ болгон шинэ хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлж байна. Архинд донтох өвчтэй хүмүүсийн хэсэг нэлээдгүй байсан тул тус газраас архины эмчилгээний төв байгуулж, иргэдэд дэмжлэг үзүүлж, эмчилгээ хийдэг. Нэмж дурьдахад хөтөлбөрт хамрагдаад гарч байгаа хүмүүст дэмжлэг үзүүлэх, тэдний бие даахад нь туслахын тулд орон байр шаардлагатай байсан бөгөөд тус хэлтэс Дархан хотын захад ферм/орон байрны хөтөлбөрийг эхлүүлэхээр ажиллаж эхэлсэн байсан.

Энэ маягаар Улаанбаатар хотод хотын түр хоноглох байранд хөтөлбөрүүдээ өргөжүүлж, үйлчилгээнийхээ төрлийг олшруулж байгаа, мөн “Өлзийт Асралт” ТББ

хөдөлмөрийн чадвар олгох сургалт зохион байгуулж, иргэдийн бие даах байдлыг цаашид дэмжих үүднээс орон байрны сонголтуудыг өргөжүүлэх арга замын талаар төлөвлөж эхэлжээ. Энэ нь халамж үйлчилгээний үйл ажиллагаа улам илүү төрөлжиж, гэр оронгүй хүмүүсийн өөр өөрийн гэсэн онцлог ялгаатай хэрэгцээнд тохируулан анхаарсан илүү үр дүнтэй чиг хандлага юм. IV.В бүлэгт бид халамжийн үйлчилгээний төрлүүд, тэдгээрийг цаашид өргөжүүлэх боломжийн талаар илүү гүнзгий танилцуулах болно.

С. Олон салбараас оролцогч талуудтай хамтран ажиллах тухай

Гэр оронгүйдлийн асуудлыг шийдвэрлэхэд нийгмийг бүхэлд нь хамарсан цогц арга барил, зарчим баримтлах нь үр дүнтэй гэж ДГОХ үздэг. Дан ганцаараа гэр оронгүй байдлыг таслан зогсоож чадах нэг ч хувь хүн, байгууллага, агентлаг байхгүй. Гэр оронгүйдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, таслан зогсоох үр дүнтэй бодлого, хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэхийн тулд олон оролцогч талууд хамтран ажиллах шаардлагатай. Эдгээр сонирхогч талуудад: гэр оронгүй амьдралаар явж байсан хүмүүс буюу даван туулагчид; орон сууц, гэр оронгүй хүмүүсийн асуудлыг хариуцдаг орон нутгийн болон үндэсний төрийн байгууллагууд; гэр оронгүй, шаардлага хангаагүй орон сууцанд амьдарч буй иргэдэд орон байр, орон сууц, үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага; эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид; хууль зүйн мэргэжилтнүүд; судлаач, эрдэмтэд; статистикийн газрууд болон бусад газруудыг нэрлэж болно.

ХНХЯ нь “Өлзийт Асралт” зэрэг ТББ-ууд, “Когнос Интернэйшнл” ХХК-ийн Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг зэрэг судлаачид, “Энэрэл эмнэлэг” зэрэг эрүүл мэндийн байгууллагууд, мөн ДГОХ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, эдгээр харилцааг бий болгож, хөгжүүлэхийн тулд идэвхтэй ажиллаж байгааг бид ажиглалаа. Цаашид ХНХЯ-ыг төр, хувийн хэвшлийн түншлэлээ ялангуяа гэр оронгүй амьдралыг даван туулагчид, амьдрах болон түр хоноглох байр, үйлчилгээ үзүүлдэг ТББ-ууд, судлаачидтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлж, өргөжүүлэхийг уриалж байна. Түүнчлэн Барилга, Хот Байгуулалтын Яам, Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний статистикийн хороо зэрэг засгийн газар, салбар хоорондын харилцааг үргэлжлүүлэн хөгжүүлэхийг уриалж байна. ДГОХ-ийн зүгээс төр, хувийн хэвшлийн харилцааг бэхжүүлэхийг дэмжихэд нь дэм болох оролцогч талуудын тогтмол судалгааг боловсруулж, явуулах, мөн олон нийтийн оролцооны бүтэц, зохион байгуулалтын талаар санал зөвлөмж өгч ажилладаг.

Гэр оронгүйдлийн асуудлаар холбогдох яамдууд хамтран улирал тутам хуралдаж байхыг зөвлөж байна. Энэхүү асуудлын нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан ХНХЯ дангаараа гэр оронгүйдлийг арилгах боломжгүй юм. Бусад яамд гэр оронгүйдлийн асуудал өөрийнх нь салбартай хэрхэн холбогдож байгаа, түүнийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг бэхжүүлж, сулруулж буй бодлого, хууль тогтоомжуудыг судлан тодорхойлох, санхүүгийн болон хүн хүчний зардлыг тооцоолон боловсруулах зорилгоор ХНХЯ-тай тогтмол уулзаж байх шаардлагатай. Яамдууд хамтран гэр оронгүйдлийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд харилцан уялдаатай стратеги, хамтын нөөцийг бүрдүүлэх ёстой.

Үүний нэг тод жишээ бол АНУ-ын яамд хоорондын хамтын ажиллагаанаас үүссэн АНУ-ын Гэр Оронгүйдлийн Хамтарсан Зөвлөл (АГОХЗ) юм. АГОХЗ Эрүүл мэнд, Хүний Үйлчилгээний яам, Боловсрол, Хөдөлмөр, Орон сууц Хот Хөгжүүлэх, Ахмад Зүтгэлтний, ХАА-н, Худалдаа, Батлан хамгаалах, Эрчим хүч, Дотоодыг хамгаалах, Дотоод Хэрэг, Хуульзүй, Тээвэр, болон бусад яамдыг оролцуулсан нийт 19 яамдын удирдагчдаас бүрддэг. АГОХЗ нь дарга, дэд даргатай бөгөөд, жилд 4 удаа уулзалдаж, гэр оронгүйдлийн асуудлаар үндэсний төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөнд багтсан зорилгодоо нийцсэн ажлуудыг хэрэгжүүлдэг.

D. Судалгаа, оролцогч талуудын хувь нэмэр

Гэр оронгүйдлийн асуудалд хандах хамгийн анхны алхам бол асуудлын хүрээг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, оролцогч хамтрагч талууд болон хэрэглэгчийн оруулах хувь нэмрийг тодорхойлох зэрэг асуудал юм. Бодлого боловсруулах, хөтөлбөрт хэрэглэж болохоор олон тооны мэдээлэл дата бэлэн байгаагаас дурдвал: Нийслэлийн Халамжийн хэлтэсээс цуглуулсан мэдээлэл, УБ дахь гэр оронгүй иргэдийн нөхцөл байдлын түргэвчилсэн судалгаа гэх зэрэг байна.

Одоогийн байгаа өгөгдлийг ашиглах нь хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх, хөтөлбөрийг түргэн хугацаанд хэрэгжүүлэх, нөхцөл байдалдаа тохируулан өөрчлөлт хийх боломжийг олгоно. Эдгээр мэдээлэл нь бодлого боловсруулах, нөөцийг үр ашигтай хуваарилах, хэрэгцээт иргэдэд үйлчилгээг хүргэхэд үндсэн суурь нь болох юм. Өгөгдлийг гэр оронгүйдэл үүсэхээс өмнө урьдчилан сэргийлэхэд ашиглаж болно. Жишээлбэл, Австрали, Финланд, Норвеги, Шотланд, АНУ-д гэр оронгүй иргэдийн эрсдэл, хүчин зүйлсийг ойлгох, гэр оронгүй болохоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг бий болгох зорилгоор судалгаа явуулдаг.

Монгол Улсын хувьд дараагийн алхам бол гэр оронгүй хүмүүсийн тооллогыг үндэсний хэмжээнд явуулах явдал бөгөөд одоо байгаа мэдээллийг аргачлал зохиох, өнөөгийн хэрэгцээ, чиг хандлагыг тодорхойлох, халуун цэг, түлхүүр мэдээлэгчдийг тодорхойлоход ашиглах боломжтой.

IV. Хэрэгцээ шаардлага, боломжууд

A. Өргөтгөсөн сууцны хэрэгцээ шаардлага

Энэ салбарт үйлчилгээ үзүүлж буй хүмүүстэй уулзаж ярилцахад, гэр оронгүй иргэдийг цаашид бие даан амьдрахад нь амьдрах байртай болоход нь туслалцаа үзүүлэх, ялангуяа ажилтай болсон иргэдэд энэ талын дэмжлэг үзүүлэх нь чухал байна гэж онцолж байлаа. Монгол улсад түр хоноглох байр, нийтийн байрнаас илүү бие даасан хэрнээ тодорхой түвшинд дэмжлэгтэй байр руу шилжин орох боломж байгаа нь ажиглагдсан. Жишээлбэл, Вангардын хамтран ажилладаг Уругвай улсад, Нийгмийн хөгжлийн Яам нь Орон сууцны Яамтайгаа хамтран хотын эргэн тойронд 3-4 ганц бие эрэгтэйчүүд нэг дор орох боломжтой байрнуудтай жижиг хэмжээний орон сууцны хороолол байгуулсан. Тэдгээр эрчүүдийн хувьд бие даан амьдрах хүсэлтэй хэдий ч архинаас гарч эрүүл

амьдралаар амьдрахад нь сэтгэлзүйн дэмжлэг тусламж хэрэгтэй, мөн хөдөлмөрийн ур чадвар, ажил хөдөлмөрийн түүхээ хадгалах, эргэн нийгэмшихэд нь дэмжлэг хэрэгтэй хүмүүс байдаг.

Вангардын хамтрагч Чикаго хотын нэгэн жишээ: Хотын захиргаанаас хотын эргэн тойронд хүн ам бага оршин суудаг орчны орон сууцнуудад ТББ-уудтай хамтран иргэд, өрхүүдэд 24 хүртэлх сарын байрны түрээс, хэрэглээний зардлыг олгож, хөдөлмөрийн ур чадвараа хөгжүүлэх, нийгэмших хугацаанд нь нийгмийн ажилтан/сэтгэлзүйчийн туслалцаа үзүүлдэг.

Тусламж авах тодорхой хугацаа заасан хөтөлбөрийн хувьд тухайн хүн, гэр бүлийг хөтөлбөрийн төгсгөлд бүрэн бие даах чадвартай болгох бодит төлөвлөгөөтэйгээр кэйс менежэр нь дэмжиж ажиллах нь чухал бөгөөд эс тэгвээс тэд гэр оронгүй байдалдаа буцаад орох өндөр магадлалтай байдаг. Вангард хөтөлбөрийн гишүүн Бразилийн Сан Пауло хот Риэнконтро нэртэй дээрхтэй ижил төстэй нэгэн хөтөлбөрийн хүрээнд өндөр чанартай, боломжийн үнэтэй тээврийн чингэлгээр барьсан сууцаар жижиг тосгон байгуулсан бөгөөд гэр оронгүй болсон хүүхэдтэй эмэгтэйчүүд ажил, боловсрол эзэмшихийн зэрэгцээ хэдэн сарын турш амьдрах боломжтой. Эцэг эх нь ажилтай болж, гэр бүлээ орон сууцтай болгох боломжтой болсон үедээ тэд шинэ байранд нүүж очсон ч бие даах чадвартай болох хүртэл шилжилтийн үеийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд түр зуурын санхүүгийн дэмжлэг авах боломжтой хэвээр байна.

Мөн өөр нэг жишээ бол ‘Нэн тэргүүнд гэр оронтой болгох’ буюу “Housing First” загварыг дэлхийн олон оронд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бодисын хэрэглээний асуудалтай хүмүүсийг байрлуулахад өргөн ашигладаг. “Housing First” загварт иргэд хаана амьдрахаа сонгох эрхтэй бөгөөд тэд орлогынхоо 30 хувийг түрээсийн төлбөрт төлж, орон сууцныхаа зардлын үлдсэн хэсгийг засгийн газрын татаасаар нөхдөг. Тус хөтөлбөрт хүмүүсийг кэйс менежментийн үйлчилгээнд оруулж нийгэмшүүлэх, сэтгэцийн болон бие махбодийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах, орон байртай хэвээр үлдэхэд шаардлагатай бусад тусламжийг үзүүлдэг байна.

В.Нийгмийн халамж, эрүүл мэндийн хөтөлбөрийн хүртээмж, тусламжийн үйлчилгээг илүү сайжруулах тухай

Дэмжин туслах үйлчилгээ нь гэр оронгүй болж зовж шаналж буй хүмүүст тэдний хэрэгцээг хангах, ахиц дэвшил гаргахад нь туслах чухал хэрэгсэл болдог. ДГОХ-ын Вангаард хөтөлбөрийн үнэлгээ болон хотуудтай хийсэн бидний ажлын үр дүнд тулгуурлан гэр оронгүйдлийн түвшинг бууруулахад чухал нөлөө үзүүлдэг арга хэмжээ, тусламж үйлчилгээнүүд байдаг. Эдгээр нь гэр оронгүйдэлтэй тулгарсан хүмүүсийг

- Бичиг баримттай болгох;
- Төрөөс олгодог нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамруулах;
- Сэтгэцийн эрүүл мэнд, анхан шатны тусламж үйлчилгээ зэрэг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах;
- Тухайн хүний хэрэгцээнд чиглэгдсэн, хүн төвтэй зарчимд суурилсан кейс менежментийн үйлчилгээг хүргэх;
- Бодисын хэрэглээ ба хор хөнөөлийг бууруулахад нь туслах зэрэг багтана.

Дараах жишээнд тодорхой улс орны жишээг танилцуулья. Хавсралтаас тодорхой эх үүсвэрүүдтэй танилцана уу:

Австрали улсад гэр оронгүй иргэдэд дэмжлэг үзүүлэх дэмжлэгт орон сууц байдаг ба үүнийг "түрээслэгчдэд боломжийн үнээр түрээслүүлэх, үнийг тогтвортой байлгах зэрэг эрүүл мэнд болон амьдралын бусад тал дээр нь туслахад чиглэсэн аливаа тусламжийн багц" гэж тодорхойлсон байдаг. Дэмжлэгт орон сууцыг нийтийн орон сууцаар хангагч байгууллагууд, ТББ-ууд болон төрийн эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олгодог. Австралид орон сууцны дэмжлэг үзүүлэх загваруудыг янз бүрийн аргаар зохион бүтээсэн байдаг бөгөөд үзүүлж буй үйлчилгээ нь тухайн загварт үйлчилж буй хүн амын хэрэгцээ шаардлага, онцлогоос хамаарч өөр өөр байдаг. Жишээлбэл, залуучуудад зориулсан орон сууцны дэмжлэг үзүүлэх хөтөлбөр нь гэр орон гэргүй ахмад настанд чиглэсэн хөтөлбөрөөс өөр үйлчилгээ үзүүлдэг. Хөтөлбөр бүр тусламжийн үйлчилгээгээ газар дээр нь үзүүлэхдээ бөөнд нь цугларсан эсвэл тархсан орчинд уу гэдгээрээ ялгаатай. Зарим тохиолдолд давхардсан онцлог байдаг. Жишээ нь Викториа Засан Хүмүүжих газраас хорих ангиас гарч, нийгэмд эргэн орж буй хоригдлуудад шилжилтийн үеийн төрөл бүрийн дэмжлэг үзүүлдэг.

С.Амьдрах зардал/Хямд төлбөртэй сууцнууд

Монголд Улаанбаатар хотыг тойрсон гэр хороолол өргөжиж, орон даяар хямд үнэтэй орон сууцны эрэлт хэрэгцээ улам ихэсч байгааг бид харсан. Хот гайхалтай түргэн өсөж, хөдөө орон нутгаас хот руу шилжих шилжилт хөдөлгөөн үргэлжилсээр байгаа тул хямд үнэтэй орон сууцны эрэлт нэмэгдэж, улмаар амьдралын баталгаагүй нөхцөл байдалд хүмүүсийг улам түлхэж, гэр оронгүй болоход хүргэнэ. Гэр оронгүй иргэдийн судалгааны тайлангаас харахад гэр оронгүй болсон иргэдийн 35 хувь нь ажлын байртай байгаа нь орлогодоо тааруулж түрээсээ төлж чадах хүн ам байгааг харуулж байна.

Хямд төлбөртэй орон сууц нь хүмүүсийг ядуурлаас ангижрахад нь дэмжлэг үзүүлж, эдийн засгийн өсөлт, сайн сайхан байдлыг цаашид нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Тогтвортой, хямд орон сууц нь хувь хүн, гэр бүлийн санхүүгийн ачааллыг бууруулж, эрүүл мэнд, боловсрол болон бусад чухал хэрэгцээнд хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог бөгөөд ингэснээр тэдний амьдралын чанарыг бүхэлд нь сайжруулж, эдийн засгийн үр дүнг сайжруулдаг. Чанартай орон сууц нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хэт ачаалалтай байх зэрэг амьдралын муу нөхцөлтэй холбоотой эрүүл мэндийн аюулд өртөх эрсдэлийг бууруулж, бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлдөг. Тогтвортой орон сууцны орчин нь хүүхдийн амьдралын тогтворгүй нөхцөл байдал, байнгын нүүдлээс хамаарсан хичээл тасалдалтад өртөх магадлалыг багасгадаг тул тэдний боловсролын чанарт хувь нэмэр оруулдаг. Эцэст нь, хямд үнэтэй орон сууц нь олон нийтийн харилцааг бэхжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулж, нийгмийн тогтвортой байдал, эв нэгдлийг бий болгоход хувь нэмэр оруулдаг.

Орон сууцны үнэ нэмэгдэж байгаа нь дэлхийн хотуудад гэр оронгүй хүмүүсийн тоо нэмэгдэж байгаатай шууд хамааралтай бөгөөд хямд орон сууцны хэрэгцээ улам их байгааг илтгэж байна. Орон сууцны үнэ өсөхийн хэрээр хямд орон сууцны хомсдол эрчимжиж, түрээсийн үнэ өсөж, бага орлоготой өрхүүд нуруун дээрээ ачааны дийлэнх

хувийг үүрч байна. Засгийн газрууд хямд үнэтэй орон сууцны хүчтэй бодлого, хөтөлбөрүүдийг бий болгосноор илүү зөв нийгмийг бүтээдэг.

"Хүмүүс хот суурин газарт ажиллаж амьдрахаар нүүдэллэн ирэх тусам амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд хотжилтыг илүү сайн төлөвлөх, нийгмийн үйлчилгээ болон өрх айлуудын хөршийн хоорондын харилцан холбоо сайтай орчныг бүрдүүлсэн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чухал шаардлагатай байна "

Дэлхийн банкны хөтөлбөрийн удирдагч Таймур Самад.

Олон улс орон иргэдээ дэмжихийн тулд хямд үнэтэй орон сууцанд хөрөнгө оруулалт хийж байна. Индонез, Япон, Шри Ланка, АНУ-ын засгийн газрууд хуучин орон сууцыг сэргээн засварлахад идэвхийлэн оролцож, одоо байгаа орон сууцны нөөцийг сайжруулахын тулд хөрөнгө оруулагчид болон эзэмшигчдэд жижиг зээл олгодог. Бага орлоготой, анх удаа орон сууц өмчлөх иргэдэд туслах зорилгоор төрөөс урьдчилгаа төлбөрийн тусламж, Индонезийн ипотекийн зээлтэй холбоотой урьдчилгаа төлбөрийн тусламж (BP2BT) зэрэг бага хүүтэй орон сууцны зээл олгодог. Хот суурин газруудад орон сууцны үнэ нэмэгдэж буйтай тэмцэхийн тулд АНУ-ын орон нутгийнхан үнэ өсөхөөс өмнө үл хөдлөх хөрөнгийг хамтран худалдаж авах, улмаар бага орлоготой хүмүүст зориулсан худалдан авах чадварыг хадгалах зорилгоор итгэмжлэлийг бий болгосон. Ийм төрлийн аргууд нь оршин суугчдад байрны асуудлыг орон нутагтаа шийдвэрлэх боломжийг олгодог.

Европын орнуудад түрээслэгчдийн эрх, түрээсийн хяналтын механизмыг бэхжүүлэх, өсөн нэмэгдсээр байгаа эрэлттэй уялдуулан хотын захиргааг хямд орон сууцыг нэмэгдүүлэх бодлого баримтлахыг дэмжих, түлхэц өгөх аргуудыг хэрэглэж байна. Түрээслэгчдийг дэмжих нь орон сууцны шударга хууль тогтоомжийг тогтоох, хэрэгжүүлэх, аюулгүй байдал, засвар үйлчилгээ эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаас үүдэн түрээслэгчдэд өргөдөл гомдол гаргах боломжийг олгох давуу талтай байдаг. Түрээсийн хамгаалалт нь орон сууцны нийлүүлэлт, түрээслүүлэгчид хамааралгүй.¹

D. Хөдөө орон нутгаас хот руу ирэх шилжилт хөдөлгөөн

Уур амьсгалын өөрчлөлт, хүнд хатуу өвлийн цаг агаар монголын уламжлалт мал аж ахуй эрхлэгч нүүдэлчдэд хүндээр нөлөөлж байна хэмээн олон оролцогч талууд ярьж байлаа. Малын хорогдол, алдагдсан мал сүргээ нөхөх санхүүгийн эх үүсвэр хомс байгаа нь нүүдэлчин айлууд тал нутгаас Улаанбаатар хотыг чиглэн хөдлөхөд хүргэдэг гэсэн үг юм. Нүүдэлчин гэр бүлүүдэд нөхцөл байдалд зохицон амьдрах, уламжлалт амьдралын хэв маягаа хадгалахад нь дэмжлэг үзүүлэх нь чухал хөрөнгө оруулалт юм. Хот руу нүүх нь зарим өрхөд зайлшгүй шаардлагатай алхам боловч хотод тохиромжтой ажил, орон сууц олох нь төсөөлж байснаас илүү хүнд байдаг. Энэхүү бэрхшээл нь хувь хүмүүс болон өрхүүдийг гэр оронгүйдлийн бусад хэлбэрт өртөх эрсдэлд оруулж хангалтгүй, баталгаагүй байранд амьдрахад хүргэх эрсдэлтэй.

¹ <https://www.smf.co.uk/stronger-protections-for-renters-wont-drive-landlords-out-of-the-market-analysis-shows/>

